



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2020.3.10 № 03/463
танай _____-ны № _____-т

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар Үндэсний хөгжлийн газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцэн шийдвэрлэсэн Төрийн албаны зөвлөлийн 63 дугаар тогтоолыг үүгээр хүргүүлж байна.

Зөвшөөрлийг үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг баталсан шийдвэрийг ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн,

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА

20200310



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 3 сарын 04 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоол, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, "Үндэсний хөгжлийн газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 192 дугаар захирамж, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Судалгаа шинжилгээний газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хөрөнгө оруулалтын дэмжлэг сурталчилгааны хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Орон нутаг, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Байгаль орчин, аялал жуулчлал, хот байгуулалтын салбар хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Судалгаа, шинжилгээний газрын ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Олон улсын гэрээ, хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн ахлах

20000227

мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Хуулийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Гадаад харилцааны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Мэдээллийн технологи, техник хангамжийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар, Батлан хамгаалах, мэдээлэл технологийн салбар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр, Уул уурхай, хүнд үйлдвэр, эрчим хүч, нийгмийн салбар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар, Эрүүл мэнд, боловсрол, хууль зүйн салбар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар, Гадаад харилцаа, худалдааны салбар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 27 дугаар, Бүс нутаг, хот төлөвлөлт, зам тээврийн салбар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 28 дугаар, Судалгаа, шинжилгээний газрын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 29 дүгээр, Хөрөнгө оруулалт бодлого, зохицуулалтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 30 дугаар, Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны хэлтсийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 31 дүгээр, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 32 дугаар, Хууль тогтоомжийн хэрэгжилт, үндэсний хөтөлбөр хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 33 дугаар, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 34 дүгээр хавсралт ёсоор тус тус батлахыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газрын дарга /Б.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны даргад даалгасугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ГИШҮҮН



Б.ИДЭРЧУЛУУН